



БАТЛАВ: "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН  
БИРЖ" ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ХҮРЭЛ ГҮЙЦЭТГЭГЧ  
/Д.АНГАР/

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХ ОЛГОХ,  
АТТЕСТАТЧИЛАХ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

2014 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү удирдамж нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гишүүн брокер, дилерийн компанийн ажилтанд үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох, аттестатчилах шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2. Шалгалтын удирдамж нь "МХБ-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-д нийцсэн байна.
3. Шалгалтыг зохион байгуулахдаа "МХБ-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам", энэхүү удирдамжийг дагаж мөрдөнө.

ХОЁР. Шалгалтын ажиллагааг зохион байгуулах

4. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2014 оын 09 сарын 04-ний өдрийн 139 тоот тушаалаар байгуулагдсан "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох шалгалт зохион байгуулах орон тооны бус комисс" /цаашид комисс гэх/ гишүүн брокер, дилерийн компанийн ажилтанд үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох, аттестатчилахтай холбогдон явуулах шалгалтыг зохион байгуулах ажлыг хариуцна.

ГУРАВ. Шалгалтын хамрах хүрээ, явуулах хэлбэр

5. Энэхүү удирдамжийн дөрөв-т заасан шаардлагыг хангасан, арилжаанд оролцох эрхийн үнэмлэх авах болон сунгах хүсэлтэй этгээд шалгалтанд оролцоно.
6. Шалгалтыг үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт, СЗХ, МХБ-ээс гаргасан журам, заавар, ёс зүйн болон үнэт цаасны зах зээлийн талаарх үндсэн мэдлэгийн сэдвүүдийг хамруулан, төстийн хэлбэрээр явуулна.

ДӨРӨВ. Шалгалт өгөх этгээдэд тавигдах шаардлага

7. Шалгалтанд орох этгээд нь холбогдох журмын дагуу дараах шаардлагуудыг хангасан байх ёстой:
  - 7.1. Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх” авсан байх ба эрхийн хүчинтэй байх хугацаа дуусаагүй байх,
  - 7.2. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад 6 сараас доошгүй хугацаанд үндсэн үйл ажиллагааг хариуцан ажиллаж зохих хэмжээнд дадлагажсан байх;
  - 7.3. Сүүлийн 1 жилийн дотор МХБ-ийн “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 4.4.1- 4.4.3 дугаар заалтуудыг зөрчөөгүй байх,
  - 7.4. Эрх авах этгээд нь брокер, дилерийн компанийн захирал, брокер ба дилерийн аль нэг албан тушаалд томилогдсон байх;
  - 7.5. МХБ ХК-ийн арилжааны программ болон дэгтэй урьдчилан танилцаж, холбогдох албанаас зөвлөмж авсан байх;
  - 7.6. Шалгалтын хураамж 100 000 /зуун мянган төгрөг/ төгрөгийг МХБ-д тушаасан байх ёстой.

#### ТАВ. Бүрдүүлэх материал

8. Шалгалт өгөх этгээд дараах баримтыг бүрдүүлж, МХБ-д ирүүлнэ.
  - 8.1. Шалгалтанд оруулахыг хүссэн компанийн албан бичиг,
  - 8.2. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх"-ний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,
  - 8.3. 3x4 хэмжээний 2 хувь зураг,
  - 8.4. Шалгалтын хураамж төлсөн баримт.

#### ЗУРГАА. Материал ирүүлэх хугацаа, хаяг

9. Шалгалт өгөх этгээд нь энэхүү удирдамжийн Тавд заасан шаардлага хангасан материалуудыг 2014 оны 10 дугаар сарын 22-ноос 31-ний өдрийг дуустал Монголын хөрөнгийн биржийн “Бүртгэлийн алба”-д ирүүлнэ.

Хаяг: МХБ-ийн “Бүртгэлийн алба”, Их Эзэн Чингис хааны талбай-3

Утас: 321411-140, Мэйл хаяг: [listing@mse.mn](mailto:listing@mse.mn), [membership@mse.mn](mailto:membership@mse.mn)

#### ДОЛОО. Шалгалт явуулах газар, хугацаа

10. Шалгалтыг 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр 14:00 цагт Монголын хөрөнгийн биржийн байранд авна.
11. Шалгалт өгөх этгээд товлосон цагаас 10 минутын өмнө ирж байраа эзэлсэн байна.

### НАЙМ. Шалгалтын дүнг гаргах

12. Шалгалтыг тест хэлбэрээр авах ба нийт 50 асуултаас бүрдэнэ. Нийт асуултын 75 ба түүнээс дээш хувийг зөв хариулсан тохиолдолд тус ажилтанг шалгалтанд тэнцсэнд тооцно.
13. Комисс нь шалгалтын материалуудыг холбогдох дүрэм журмын дагуу үнэн зөв, ил тод, шуурхай дүгнэж, дүнг танилцуулна.
14. Комиссын дүгнэлт, шалгалтын нэгдсэн дүнг үндэслэн шалгалтанд тэнцсэн ажилтанд Гүйцэтгэх захирлын тушаалаар МХБ-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийн үнэмлэх олгоно.
15. Шаргалтанд амжилтгүй дүн үзүүлсэн ажилтан нь МХБ-ийн “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 3.6 дугаар заалтыг үндэслэн давтан шалгалтанд орох боломжтой.

### ЕС. Бусад

16. Шалгалтын материалыг үнэлж дүгнэхэд шударга бус хандаж, үнэлгээний стандартыг буруу хэрэглэсний хариуцлагыг уг шалгалтыг дүгнэсэн комиссын гишүүд хариуцна.
17. Гишүүний ажилтан нь эрх олгох шалгалтын дүнтэй санал нийлэхгүй бол энэ тухай гомдлоо ажлын 5 хоногийн дотор МХБ-д гаргаж болно.

### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ